

Монгол ярдын цэс

Тав яв



Тав яс

Улаанбаатар хот
2007 он



ТАВ ЯВ

Боловсруулсан:

Хвалзийн эхийг бэлтгэсэн:

Чимэг зурагийг зурсан:

Монгол бичигээр буулгасан

Ж.Дашдондог

Т.Дэлгэрмаа

Б.Болормаа

Х.Оюунчилүүн



Хэвлэн нийтлэлийг Интерпрес ХХК


2007 он

Үрьд ганц хүүтэй чавганц байжээ. Тэднийх нэг алаг үнээтэй юмсанж. Үнээ нь жил бүр туталладаг, түүнийг бяруу болохоор нь алж иддэг юмсанжээ. Гэтэл нэг жил алаг тутал гарч, тэр туталын бяруу болохор нь хув:

- Ээж ээ! Бяруугаа алж идье гэжээ. Тэгсэнд ээж нь:
 - Хүү минь, идэж болохгүй. Чамд хүүхэн авч өгөх сүйд хэрэглэнэ гэжээ.

Гэтэл бас нэг ядуу чавганц ганцхан охинтой юм байж. Тэр чавганцын хүүхнийг ганц алаг бяруугаараа сүйлж хүүдээс эхнэр болгож өгчээ. Тэгээд чавганц нар үхэж, хүү хүүхэн хоёулхнаа улджээ.





XУУ нэг өдөр гараад, ганц үнээгээ алж орхижээ. Тэгээд үнээндийхээ элэг сэмжийг нь нэг хэрээнд өгчхөв. Үүнийг нь хуухэн мэдээд:

-Ээ, чи бас үнээнийхээ зэлг сэмжийг юунд хэрэнд өгч орхив доо. Ядуу бидэнд нэг хоёр орой гэсэн идэж хоноход аятай байх билээ гэжээ.

Тэгээд тэр хоёр үнээнийхээ махаар хэдэн өдөр амьдарч суугаад, мааха барагдахаар хүү тарвага зурам алхаар явжээ.

Нэгэн өдөр хүү нэг их модтой ууланд цангаж өлсж явж.





Тэгээд шувууны үүр байхыг харж
дотроос нь өндөг авч шарж идэх
гэж байтал хэрээ нисэн ирэв.
Хэрээ хүний хэлээр дуугарч:

- Ээ, хүү чи сайн явж байна уу? Урьд намайг нэг их өлсөж явахад чи надад тус хүргэсэн юм. Тэгэхэд би чамд хоёр удаа тус хүргэе гэж бодсон юмсан. Одоо чи намайг харж бай! Миний нисээд бусан модны ёроолд очоод газрыг нь ухаарай. Тэгтэл чинь нэг жижигхэн тогтоо гарч ирнэ. Тэр тогтоонд "Хоол унд бут!" гэхээр бутдэг юм. Чи түүнийг аваад яв.

Хэрэв дахиад зовж зүдрэх юм бол над дээр нэг ирээрэй дээ! Гээд нисч, нэг бүдүүн модны мэчир дээр очиж суужээ. Хүү тэр модны дэргэд ирж газар ухсанд нээрээ нэг жижигхэн тогоо гарчээ. "Энэ жижигхэн тогоон дотор мах хоол бол!" гэсэнд уур савссан халуун хоол буцалжээ. Хүү тэр хоолоо идчихээд, өнөөх тогогоого аваад гэртээ ирж юугаар ч дутахгүй суужээ. Тэгтэл нэг өдөр тэднийд ноёны шивэгчин ирэв.









Xүүгийн эхнэр хуучин тогогоогоо тавиад ус хийгээд түүнд цай чанах гэсэнд:

-Хүүе чи энэ хүнд үүн дотор цай чанах гэж байгаа юу? гэж хэлээд эрдэнийнхээ тогогог шүүрэн авч "Сүүтэй сайхан цай буцал!" гэсэнд дорхноо буцалжээ.

Тэгэл тэр эм цайгий нь уүчхаад ноёныд ирж:

-Тэр муу ядуу хүү чинь харин биднээс дээр сууж байна шүү. Эрдэнийн тогоогоор хоол ундаа бэлтгэж, идэжүүж байдаг билээ гэж хэлэв.

Ноён үүнийг дуулаад хүү үрүү нэг хүн явуулж, түүнийг тогоотой нь авчруулжээ. Ноён хүүгээс:

-За хө, наад тогоо чинь ядаг тогоо юм? Чинь наад үүнийхээ ид шидийг нь үзүүлээд орхиж гэсэнд хүү тогондоо "Тогоо дүүрэн сүтэй цай бий бол!" гэсэнд дүүрэн цай бушалжээ.

Ноён уунийг нь узээд хүүдээ

-За хө, чи толгойгоо авахуулах уу, аль тогоогоо
егех уу? гэжээ. Хүү бодож:

-За яахав. Үхэж орхисноос тогоогоо өгсөн нь арай дээр байлгүй дээ гээд тогоогоо өгөөд бүцжээ.



Гэртээ ирээд эхнэртээ ноён тогоогийн минь авчихлаа гэж хэлжээ. Тэгэхэд эхнэр нь:

-Чи тэр муу шивэгчин хүүхэнд гайхуулж байж тэр боллоо доо гэв.

Тэгээд хүү хэрээнд очжээ. Хэрээ:

-За чи юу гэж явна? гэсэнд хүү:

-Өнөөг тогоогий чинь ноён авчихсан гэж хэлжээ. Тэгэхэд нь хэрээ хүүд эрдэнийн алх өгөed:

-За энэ алхыг барьж "Тав яв!" гэж хэлээд ямар ч амьтан уруу дохиход тэр амьтан үхдэг юм гэжээ. Хүү өнөөх алхыг нь аваад буцаж явтал нэг тарвага гүйж яваа харагдav. Тэр тарвага уруу алхаараа "Тав яв!" гээд дохисонд тарвага үхчижжээ. Хүү тарвагаа аваад гэртээ ирээд байж байтал гадуур нь олон зээр явж байв. Түүний зүг "Тав яв!" гээд алхаараа дохиод орхисонд бугдээрээз үхчижжээ. Хүү эхнэртэйгээ зээрийн махыг цадталаа идээд байж байдаг болжээ. Тэгж тайван амьдарч байх үед нь ноёны өнөөх шивэгчин бас иржээ.

Тэр хүүхэн өнөө хоёроос:

-За та хоёр яж амьдарч байна даа? гэсэнд хүү:

-Аа, би эрдэнийн алх олж ирсэн, түүгээрээ зээр алж, тавтай сайхан сууж байна гэжээ.





иүвэгчин үүнийг дуулчхаад ноёнд ирж хүүгийн үгийг хэлжээ.

Ноён түүнийг нь дуулаад, мөн хүн явуулж хүүг алхтай нь цүг авчруулжээ.

Ноён хүүд:

- Чиний алх хө, ямар эрдэмтэй, яадаг юм? Бушуухан надад үзүүлээд орхи! гэсэнд хүү:
 - Миний алх бол эрдэнийн алх юм. Нүдэндээ харагдсан амьтан руу "Тав яв!" гээд дохиод тэр үхдэг юм гэжээ. Тэгэхээр нь ноён тэр хотын захад гүйж явваа нохойг чи дохиод орхи! гэв. Хүү заасан уруу нь "Тав яв!" гээд дохиод орхисонд нохой үхэтгийн унажээ. Тэгэхээр нь ноён хүүд бас л:
 - За чи алхaa өгөх үү, аль толгойгоо авахуулах уу? гэсэнд хүү:
 - Толгойгоо ч авахуулахгүй, алхaa ч өгөхгүй гэжээ. Тэгэхээр нь ноён уурлаж:
 - Энэ мүү задарсан нохой чинь юу гэж хуцах байгаа юм бэ? Тэр алхыг нь аваад аль! гэтэл хүү:
 - Ноён ч тав яв! Хатан ч тав яв! Ноёныхон цемөөрөө тав яв! гээд ноёныг гэр бүлтэй нь тонилгож орхижээ. Тэгээд хүү ноёны ширээнд сууж, хот хошууг захираад амар сайхан жаргажээ.





ЧИХЭР ХҮЛХВЭЛ АРААНД УУСНА НОМ УНШВАЛ ТОЛГОЙД ҮЛДЭНЭ

Хүүхдийн шилдэг үлгэрийн номын эхний хуудсан дээр золгож буй гүн хүндлэлт эцэг эхчүүд ээ!

Хэрэв та үр хүүхдээс сайн ном авч өгөвөл тэднийг хүмүүжүүлэх их ажлынхаа дийлэнх хувийг хийлээ гэж найдаж болно. Үлгэрийн баатрууд тэдэнд туслах мэргэн оюун, уран сэтгэмж, сайхан сэтгэлийг бэлэглэнэ.

Таны хүүхдүүд энэ номоор дамжин үсээ нудэлж үг холбосоор үлгэрийн гайхамшигт ертөнц рүү орж байна. Чихэрт дургүй хүүхэд гэж байдаггүй. Чихэр гагцхүү амтлах эрхтэнд нөлөөлдөг бол ном таван мэдрэхүйг эзэмдэнэ. Тиймээс номын амт нь чихрийнхээс хавьгүй илүү болохыг хүүхдүүд аяндаа мэдэрнэ. Энэхүү номын зурийг уран сайхны өндөр түвшинд урласан миний шавь Б.Болормаа 2005 онд Олон улсын НОМА уралдааны Гран при шагнал хүртэж Монголын хүүхдийн номын зураачдын нарийг дэлхийн сонорт хүргэсэн билээ. Ийнхүү шилдэг үлгэр, сайхан зураг найрсан нийлсэн номын амтат чихрийг үр хүүхдийн тань гарт атгуулья. Таалан соёрхоно уу?



Олон улсын хүүхдийн утга зохиолын дөрвөн удаагийн шагналт, зохиолч
Жамбын Дашдондог



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) тесөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.